НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** НТАГ-2021/1/СТА-ТЕЗ


Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Аудитын 2 дугаар хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: З.Мөнхбаяр
Утас: 327734 Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Долгорсүрэн
Утас: 325093 Цахим хаяг: dolgorsureng@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 20 өдөр Дугаар А/13 Улаанбаатар хот

**Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаартай "Эрх, үүрэг шилжүүлэх тухай" тушаалын 5 дугаар хавсралт, 2021 оны Б/08 дугаартай "Албан үүрэг түр орлон гүйцэтгүүлэх тухай" тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг (НТАГ-2021/1/СТА-ТЕЗ) хавсралтаар батлсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг 2021 оны 10 дугаар сарын 1-ний дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-д зөвлөсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2021 оны 3 дугаар улиралд гаргаж танилцуулахыг аудитын хоёрдугаар хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /З.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.

4. Аудитын тайланг ҮАГ, НИТХ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.ЭРДЭНЭЖАРГАЛ

D:\Desktop\2021 oн\2021\Bopд\Тушаал\... 2021.04.20 ...tuhai.docx 002010047

Агуулга

1. Аудитын гэрчилгээ ....................................................................................................... 4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан ................................ 7
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ........................................................ 7
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ..................................................... 8
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ........................................................... 9
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .................................. 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .................................................................... 11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ................................................................... 12
3. Аудитын тайлан ............................................................................................................ 13
3.1 Ерөнхий зүйл ................................................................................................................ 13
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ...................................................... 13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .............................................. 13
3.4 Материаллаг байдал ..................................................................................................... 14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .................................................................... 14
3.5.1 Мөнгөн хөрөнгө ......................................................................................................... 14
3.5.2 Авлага ...................................................................................................................... 15
3.5.3 Урьдчилгаа ............................................................................................................... 17
3.5.4 Бараа материал ......................................................................................................... 18
3.5.5 Үндсэн хөрөнгө ......................................................................................................... 19
3.5.6 Өр төлбөр ................................................................................................................. 21
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо ..................................................................................... 22
3.5.8 Орлогын данс ............................................................................................................ 23
3.5.9 Зардлын данс ............................................................................................................ 23
3.6 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд ............................................ 25
3.7 Шилэн дансны мэдээлэл ................................................................................................ 26
3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........................................ 26
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ............................................... 26
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ................... 28
3.11 Аудитын зөвлөмж ........................................................................................................ 28
4. Хавсралтууд ................................................................................................................. 33

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| ТАБ | Төрийн аудитын байгууллага |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |
| НББОУС | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ОНӨААН | Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж |
| ОНӨТҮГ | Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ААН | Аж ахуйн нэгж |
| БГД | Баянгол дүүрэг |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| ХУД | Хан-Уул дүүрэг |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| БНД | Багануур дүүрэг |
| НД | Налайх дүүрэг |
| БХД | Багахангай дүүрэг |
| НИТХ | Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НЗДТГ | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| НХОГ | Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар |
| НӨАУГ | Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар |
| ЖДҮҮДТ | Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв |
| ОНСААУГ | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар |
| УСУГ | Ус сувгийн удирдах газар |
| ХИХУГ | Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХК | Хувьцаат компани |

## 1. Аудитын гэрчилгээ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.04.20 № 832
танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ,ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
Д.СУМЪЯАБАЗАР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Нийслэлийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Нийслэлийн Засаг даргын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 бүлэг 26 зорилтын хүрээнд 493 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

00202062б

**Аудитын гол асуудал**

Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болсон. Тухайлбал:

- Худалдан авалт болон бараа, ажил үйлчилгээний төлбөрийн 12,712.2 сая төгрөгийг и-баримтын дүнгээс зөрүүтэй шилжүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;
- Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газраас 2014-2016 онд хадгаламж зээлийн хоршоодод олгосон зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл 7,989.5 сая төгрөгийг гэрээний дагуу барагдуулаагүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;
- "Нийтийн тээврийн шинэ шийдэл төсөл, парк шинэчлэлт, хүүхдийн сургуулийн автобус төсөл"-ийн хүрээнд 5 ширхэг автобусыг хүлээн авахдаа бүртгэлд тусгаж авлагыг бууруулаагүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, тухайн гэрээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй мөн шүүхийн шийдвэртэй авлагыг барагдуулаагүй, өр төлбөрийг дутуу тайлагнасан зэрэг нийт 2,784.0 сая төгрөг;
- Нийслэлийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төсөв баталж зарцуулахдаа баримтлах дүрэм, журам, шалгуур үзүүлэлт тодорхой бус, төслийн зорилго хоорондоо хамааралгүй, уялдаагүй, тайлант онд бүрэн гүйцэт хэрэгжээгүй, үлдэгдэл санхүүжилтийн ажлын явц тодорхойгүй,
- Нийт 7,332.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмыг хэрэглээгүй, холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн зэрэг зөрчлүүд нь оршин байх, үнэн зөв байдал, иж бүрэн байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\Desktop\2021 он\2021\[illegible]\2021.04.20 НЗО docx

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

| Д/д | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 899,296,871.6 | 1,580,852,348.9 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 331,933,613.6 | 314,992,268.2 |
| 33 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 86,992,495.8 | 220,226,521.2 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 7а, 7б | 11,721,591.2 | 25,099,960.6 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 78,676,708.9 | 90,511,331.4 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 9а | 267,088.2 | 40,967.9 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 10 | 389,705,373.9 | 929,981,299.7 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 2,867,686,525.5 | 2,870,344,638.4 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 11а, 11б | - | 980.0 |
| 37300 | Урт хугацаат зээл | | - | 980.0 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 2,867,686,525.5 | 2,870,343,658.4 |
| 39100 | Газар | | - | - |
| 39200 | Биет хөрөнгө | | 1,963,650,483.3 | 1,999,725,924.8 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13 | 890,979,488.6 | 824,319,780.2 |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 14 | 13,056,553.6 | 46,297,953.4 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 3,766,983,397.1 | 4,451,196,987.3 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 419,593,635.9 | 992,131,761.0 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15а, 15б | 83,317,006.4 | 144,443,968.5 |
| 41300 | Өглөг | 17а, 17б | 53,234,710.2 | 92,985,378.6 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 18а, 18б | 30,082,296.1 | 51,458,589.9 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 336,276,629.6 | 847,687,792.5 |
| 42200 | Урт хугацаат зээл | 20а, 20б | 336,276,629.6 | 847,687,792.5 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 3,347,389,761.2 | 3,459,065,226.3 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 3,347,389,761.2 | 3,459,065,226.3 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 1,083,221,970.3 | 1,010,600,117.0 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 289,318,155.2 | 351,212,816.5 |
| 51103 | Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/ | | 44,472,187.4 | - |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | | 372,114,930.6 | 396,080,593.4 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 741,246,833.9 | 892,384,771.4 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 817,015,683.8 | 808,786,928.0 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 3,766,983,397.1 | 4,451,196,987.3 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Д/д | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | **1,869,232,974.8** | **2,157,765,271.4** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 857,305,987.6 | 758,813,254.8 |
| 110 | Орлогын албан татвар | | 645,611,289.6 | 550,728,589.5 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 666,528,895.0 | 570,990,714.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | (20,917,605.4) | (20,262,124.6) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 93,431,513.9 | 85,932,854.4 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 118,263,184.1 | 122,151,810.9 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 866,964,826.2 | 1,275,877,501.0 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 440,096,163.2 | 747,161,453.5 |
| 121 | Хөрөнгийн орлого | | 314,974.0 | 20,751,309.6 |
| 122 | Тусламжийн орлого | | 1,986,935.4 | 9,506,614.8 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | 424,566,753.6 | 498,458,123.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 144,962,161.1 | 123,074,515.6 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2а, 2б** | **1,862,760,244.9** | **1,773,710,486.8** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,849,581,354.4 | 1,773,710,486.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,374,090,788.7 | 1,413,521,470.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 376,933,985.1 | 443,913,507.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 47,496,964.1 | 56,230,700.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 52,823,270.4 | 55,995,653.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 238,990,227.8 | 178,867,883.2 |
| 2105 | Нормативт зардал | | 24,098,516.3 | 35,685,829.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 17,080,164.7 | 15,801,572.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 3,748,234.7 | 624,023.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 153,603,034.5 | 175,871,229.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 459,316,391.2 | 450,531,070.6 |
| 211 | ХҮҮ | | 4,564,561.1 | 11,090,324.8 |
| 212 | ТАТААС | | 146,297,961.9 | 180,972,950.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 324,628,042.8 | 168,125,741.8 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 13,178,890.5 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | **6,472,729.9** | **384,054,784.6** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | | **1,011,851.8** | **726,719.2** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **92,176,497.5** | **398,078,966.8** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | | **(84,691,915.8)** | **(13,297,463.0)** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

| Д/д | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | | **1,950,079,630.3** | **1,927,245,501.5** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 857,305,987.6 | 756,793,704.8 |
| 110 | Орлогын албан татвар | | 645,611,289.6 | 550,728,589.5 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 666,528,895.0 | 570,990,714.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | (20,917,605.4) | (20,262,124.6) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 93,431,513.9 | 85,932,854.4 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 118,263,184.1 | 120,132,260.9 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | | 43,091,675.4 | 42,491,861.9 |
| 1181 | Газрын төлбөр | | 64,446,231.5 | 68,826,651.8 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | | 3,379,999.5 | 3,632,121.2 |
| 1183 | Бусад татвар | | 7,345,277.7 | 5,181,626.1 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 944,409,585.3 | 1,034,395,141.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 505,174,866.3 | 512,679,094.2 |
| 121 | Хөрөнгийн орлого | | 314,974.0 | 20,751,309.6 |
| 122 | Тусламжийн орлого | | 14,352,991.4 | 2,506,614.8 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | 424,566,753.6 | 498,458,123.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 148,364,057.4 | 136,056,655.0 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **1,563,358,635.3** | **1,568,242,522.5** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,563,358,635.3 | 1,568,242,522.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,089,682,573.4 | 1,220,836,693.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 403,299,162.1 | 472,015,522.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 64,469,522.1 | 73,578,080.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 60,384,216.2 | 64,020,179.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 110,570,594.0 | 123,914,935.2 |
| 2105 | Нормативт зардал | | 26,319,519.1 | 35,335,466.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 13,361,474.6 | 11,081,689.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 3,521,322.5 | 350,135.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 299,980,645.8 | 325,627,955.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 107,776,116.9 | 114,912,730.2 |
| 212 | ТАТААС | | 147,325,837.0 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 326,350,225.0 | 177,533,106.6 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | | **386,720,994.9** | **169,872,722.3** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | | **309,660,328.1** | **359,002,979.0** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 309,660,328.1 | (381,096,601.8) |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 309,660,328.1 | (381,096,601.8) |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | | - | - |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | | **(309,660,328.1)** | **(381,096,601.8)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | | **(94,984.1)** | 5,152,277.4 |
| 14 | Бусад эх үүсвэр | | 567,915.7 | 5,655,179.2 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | 662,899.8 | 502,901.8 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | | **76,965,682.7** | **(16,941,345.4)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 254,967,930.9 | 331,933,613.6 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 331,933,613.6 | 314,992,268.2 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Д/д | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Өөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,323,700,375.9** | **-** | **3,323,700,375.9** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 79,261,767.0 | - | 79,261,767.0 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,402,962,142.9 | - | 3,402,962,142.9 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 4,578,480.1 | - | 4,578,480.1 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 378,019.6 | - | 378,019.6 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 24,605,414.8 | - | 24,605,414.8 |
| 8 | Зарласан ногдол ашиг | (442,380.5) | - | (442,380.5) |
| 9 | Тайлант үеийн үр дүн | (84,691,915.8) | - | (84,691,915.8) |
| **10** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,347,389,761.2** | **-** | **3,347,389,761.2** |
| **11** | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,347,389,761.2** | **-** | **3,347,389,761.2** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 164,100,310.2 | - | 164,100,310.2 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,511,535,283.3 | - | 3,511,535,283.3 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (8,125,742.7) | - | (8,125,742.7) |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | (72,053,058.3) | - | (72,053,058.3) |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 41,329,667.4 | - | 41,329,667.4 |
| 18 | Зарласан ногдол ашиг | (278,248.6) | - | (278,248.6) |
| 19 | Тайлант үеийн үр дүн | (13,297,463.0) | - | (13,297,463.0) |
| **20** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,459,065,226.3** | **-** | **3,459,065,226.3** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,709,254,625.1** | **1,357,177,310.7** | **(352,077,314.4)** | **79.4** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,360,116,566.1 | 1,088,252,253.2 | (271,864,312.9) | 80.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 860,137,489.7 | 781,383,955.9 | (78,753,533.8) | 90.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 387,752,212.9 | 372,470,293.5 | (15,281,919.4) | 96.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49,226,393.8 | 46,602,369.6 | (2,624,024.2) | 94.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 44,229,609.8 | 37,806,444.4 | (6,423,165.4) | 85.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 81,936,965.6 | 68,626,060.9 | (13,310,904.7) | 83.8 |
| 2105 | Нормативт зардал | 38,693,254.8 | 27,647,699.5 | (11,045,555.3) | 71.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 18,631,947.5 | 15,813,904.8 | (2,818,042.7) | 84.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,642,175.2 | 344,165.4 | (1,298,009.8) | 21.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 135,703,624.5 | 123,091,780.5 | (12,611,844.0) | 90.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 102,321,305.6 | 88,981,237.5 | (13,340,068.1) | 87.0 |
| 211 | ХҮҮ | 6,380,736.4 | 6,380,736.4 | - | 100.0 |
| 212 | ТАТААС | 159,903,412.9 | 156,084,761.0 | (3,818,651.9) | 97.6 |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 28,255,491.0 | 26,732,828.8 | (1,522,662.2) | 94.6 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 131,647,921.9 | 129,351,932.2 | (2,295,989.7) | 98.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 333,694,927.1 | 144,402,799.9 | (189,292,127.2) | 43.3 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 301,851,545.5 | 124,317,874.5 | (177,533,671.0) | 41.2 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 31,843,381.6 | 20,084,925.4 | (11,758,456.2) | 63.1 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 349,138,059.0 | 268,925,057.5 | (80,213,001.5) | 77.0 |
| III | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,709,254,625.1** | **1,363,249,426.3** | **(346,005,198.8)** | **79.8** |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 500,006,626.4 | 475,332,287.3 | (24,674,339.1) | 95.1 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 993,649,728.3 | 865,805,629.0 | (127,844,099.3) | 87.1 |
| 33 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 279,094.7 | 53,715.8 | (225,378.9) | 19.2 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 215,319,175.7 | 22,057,794.2 | (193,261,381.5) | 10.2 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 24,873,973.3 | | |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 26,893,765.5 | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1,019 | 1,000 | (19) | 98.1 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 32,931 | 31,702 | (1,229) | 96.3 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 409,138 | 352,786 | (56,352) | 86.2 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 299,747 | 273,144 | (26,603) | 91.1 |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 109,391 | 79,642 | (29,749) | 72.8 |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО | 38,952 | 30,483 | (8,469) | 78.3 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **89,172,377.8** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 83,616,129.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 50,720,198.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 687,701.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 92,081.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,252,685.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,730,758.5 |
| 2105 | Нормативт зардал | 234,997.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,790,338.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,500.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,777,627.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,152,507.9 |
| 211 | ХҮҮ | 6,380,736.4 |
| 212 | ТАТААС | 92,632.2 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 92,632.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 26,422,562.3 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 24,705,070.8 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,717,491.5 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 5,556,248.2 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 5,556,248.2 |
| I | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **89,172,428.2** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 89,172,428.2 |
| III | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | 50.4 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 35,172.8 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 35,223.2 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, төсвийн ерөнхийлөн захирагч Д.Сумъяабазар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 4 дүгээр сарын 01-ээс 2021 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, ТЕЗ-д хүргүүлэхээр төлөвлөн, НТАГ-ын Аудитын 2 дугаар хэлтсийн ахлах аудитор Г.Долгорсүрэн, Н.Баттогоо, аудитор М.Нарангэрэл, Ш.Мөнхжаргал, гэрээт аудитор Р.Түмэн-Эрдэнэ нар гүйцэтгэв.

Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг НТАГ-т 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 01/1378 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

2020 оныг “Нэг хот нэг стандарт“ жил болгон зарлаж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээг шинэ шатанд гаргаж, шийдвэр гаргах түвшинд иргэд, оршин суугчдын саналыг тусган, хотын хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтын ажилд тэдний оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийг гол зорилго болгон ажиллажээ.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд:

- Эдийн засгийн өсөлт өрх бүрд бүлгийн 6 зорилтын хүрээнд 63 арга хэмжээ;
- Хот байгуулалт, дэд бүтэц бүлгийн 5 зорилтын хүрээнд 123 арга хэмжээ;
- Байгаль орчин, ногоон хөгжил бүлгийн 3 зорилтын хүрээнд 73 арга хэмжээ;
- Нийгмийн хөгжил бүлгийн 8 зорилтын хүрээнд 160 арга хэмжээ;
- Засаглал бүлгийн 4 зорилтын хүрээнд 74 арга хэмжээ

Нийт 5 бүлэг 26 зорилтын хүрээнд нийт 493 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5 бодлого /бүлэг/, 26 зорилт /дэд бүлэг/, 493 арга хэмжээ /заалт/-ний хэрэгжилтийг 92.5 хувьтай дүгнэсэн байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Нийслэлийн ТЕЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нийслэлийн Дотоод аудитын газрын аудит, хяналт шалгалтын 2020 оны төлөвлөгөөний дагуу нийт 38 аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 33 аудит, хяналт шалгалтыг гүйцэтгэж нийт

15,917.4 сая төгрөгийн 206 зөрчлийг илрүүлэн, 6 байгууллагад 45.3 сая төгрөгийн төлбөрийн 9 акт тогтоож, 10 байгууллагад 8,010.8 сая төгрөгийн 15 албан шаардлагыг хүргүүлж, 7,861.3 сая төгрөгийн илэрсэн асуудалд цаашид давтан гаргахгүй байх 183 зөвлөмж өгч ажилласан байна.

Нийслэлийн ТЕЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,954,936.7 сая төгрөгийн 2.0 хувь буюу 39,098.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 43,435.8 сая төгрөгөөр тогтоосон нь 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардлын дүн 216,852.7 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

### 3.5 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 331,933.6 сая, эцсийн үлдэгдэл 314,992.3 сая төгрөг болж, 16,941.3 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Кассад байгаа бэлэн мөнгө | 384.3 | 386.0 | 1.7 | 0.1 |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 319,840.3 | 304,709.6 | (15,130.7) | 96.7 |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | 11,709.0 | 9,896.7 | (1,812.3) | 3.1 |
| **Дүн** | **331,933.6** | **314,992.3** | **(16,941.3)** | **100.0** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | | |
| Төсөвт байгууллага | 42,506.5 | 43,881.2 | 1,374.7 | 13.9 |
| Төсөл/ сан | 4,405.9 | 4,407.1 | 1.2 | 1.4 |
| Төрийн сан | 178,820.7 | 164,905.6 | (13,915.1) | 52.4 |
| ОНӨҮГ | 106,200.5 | 101,798.4 | (4,402.1) | 32.3 |
| **Дүн** | **331,933.6** | **314,992.3** | **(16,941.3)** | **100.0** |

*Эх сурвалж: Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Банканд байгаа бэлэн мөнгөний 66.8 хувь буюу 203,651.5 сая төгрөг нь Төрийн санд, 33.2 хувь буюу 101,058.1 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна. Арилжааны банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн 60.0 хувь нь 10.0 тэрбум төгрөгөөс дээш үлдэгдэлтэй дараах 3 байгууллага байна. Үүнд:

- УСУГ ОНӨААТҮГ 22,841.0 сая төгрөг,
- Монгол-Оросын хамтарсан сургууль 14,530.6 сая төгрөг,
- Нийслэлийн Орон сууцны корпораци ХК 12,276.5 сая төгрөг

Төрийн санд орон нутгийн ерөнхий орлого 135,543.4 сая, барьцаа 49,594.5 сая, ОНХС-гийн зарцуулагдаагүй үлдэгдэл 11,641.7 сая, Нийтийн тээврийн үйлчилгээний газрын парк шинэчлэлийн сан 4,218.9 сая, Байгаль хамгаалах сан 188.3 сая, татан төвлөрүүлсэн

1,682.4 сая, орон сууцны орлого 782.3 сая, нийт 203,651.5 сая төгрөг байршиж байна.

Арилжааны банкны "0" үлдэгдэлтэй төсвийн орлогын харилцах данснаас гүйлгээ хаагдсаны дараа татварын 9,896.7 сая төгрөгийн орлого нийслэл, дүүргүүдийн төрийн сангийн орлогын ерөнхий дансанд 2021 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр он дамжиж орсон тул замд яваа мөнгөн хөрөнгөөр тайлагнажээ.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь Ковид-19 цар тахлын улмаас ОНӨААН-үүдийн орлогын төлөвлөгөө тасарсан, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрхийн болон зарим ААН, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх болсон зэрэгтэй холбоотой.

*Аудитын илрүүлэлт:*

*Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 13,442.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:*

- *Цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг 12,475.0 сая төгрөгийн зөрүүтэй шилжүүлсэн. /Тухайлбал, БЗД 4,612.3 сая, СБД 1,419.0 сая, ХУД 1,051.2 сая, ЧД 943.4 сая, СХД 471.2 сая, НД 340.5 сая, БНД 199.8 сая, БХД 101.9 сая, БГД 87.7 сая, НЗДТГ, Нийслэлийн Орон сууцны корпораци ХК, ОСНААУГ ОНӨААТҮГ 804.6 сая, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба 582.6 сая, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар 351.5 сая, ЖДҮҮДТ ОНӨТҮГ 316.9 сая, НӨАУГ 286.4 сая, НХОГ ОНӨААТҮГ 169.1 сая, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ 144.1 сая төгрөг/*
- *Бэлнээр 3.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 152.2 сая төгрөг зарцуулсан. /БГД/*
- *Дүүргийн Засаг даргын Тамгын газарт ажиллаж байсан эд хариуцагчийн (2020 оны 4 дүгээр сард ажлаас чөлөөлөгдсөн) Худалдаа хөгжлийн банк дахь иргэний 2612221895 тоот дансаар 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31 хүртэлх хугацаанд 141.2 сая төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээг хийсэн. /ЧД/*
- *Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 551.2 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Тухайлбал, БЗД 111.0 сая, Хот тохижилтын газар 107.2 сая, Нийслэлийн Орон сууцны корпораци ХК 58.7 сая, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 57.4 сая төгрөг/*

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 86,992.5 сая, эцсийн үлдэгдэл 220,226.5 сая төгрөг болж, 133,234.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 264.2 | 277.3 | 13.1 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 17,913.0 | 15,909.4 | (2,003.6) |
| Татаас, санхүүжилтийн авлага | 113.9 | - | (113.9) |
| Зээлийн хүүгийн авлага | 63.4 | 73.8 | 10.4 |
| Дансны авлага /ТӨҮГ/ | 3,752.9 | 18,014.1 | 14,261.2 |
| Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | 270.8 | 1,540.0 | 1,269.2 |
| Бусад авлага | 61,754.8 | 181,552.4 | 119,797.6 |
| Зээлийн авлага | 2,859.5 | 2,859.5 | - |
| **Дүн** | **86,992.5** | **220,226.5** | **133,234.0** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 37,057.0 | 31,721.3 | (5,335.7) |
| Төсөл/ сан | 27,291.7 | 27,295.9 | 4.2 |
| Төрийн сан | 305.7 | 305.7 | - |
| ОНӨҮГ | 22,338.1 | 160,903.6 | 138,565.5 |
| **Дүн** | **86,992.5** | **220,226.5** | **133,234.0** |

*Эх сурвалж: Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-ийн авлага 113,312.1 сая төгрөгөөр нэмэгдэж 113,745.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан бөгөөд дараах авлагуудыг бүртгэсэн байна. Үүнд иргэдээс авах түрээс, ашиглалтын төлбөрийн 694.7 сая, түрээслээд өмчлөх нөхцөлтэй орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд иргэдээс авах 91,509.1 сая, орон сууцаар газраа сольсон иргэдээс авах 1,889.7 сая, зээлийн хүүгийн авлага 19,629.8 сая, байгууллагаас авах 22.6 сая төгрөгөөс тус тус бүрджээ. Энэ нь авлагын үлдэгдэл нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Авлагын үлдэгдэлд олон жил болсон 39,737.4 сая төгрөгийн дараах авлагууд байна. Тухайлбал,

- Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам нь 2011 онд бүтцийн өөрчлөлтөд орсноор тус яаманд байсан нийтийн тээврийн парк шинэчлэлтийн санг нийслэлд шилжүүлсэнтэй хамт 22,291.7 сая төгрөгийн авлага шилжиж ирсэн.
- Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн сангаас нийтийн тээврийн 7 компанид эргэн төлөх нөхцөлтэйгөөр 2009 онд 10,837.1 сая төгрөг олгосон. /Нийтийн Тээврийн үйлчилгээний газар/
- Чандмань-Налайх ОНӨААТҮГ-аас авах усны төлбөр 2,822.4 сая төгрөг /УСУГ ОНӨААТҮГ/
- Азийн хөгжлийн банкны Мон-2301 төслийн зээлийн авлага 2,568.5 сая төгрөг /Нийслэлийн Авто замын хөгжлийн газар/
- Байгууллага, хувь хүмүүсээс авах, 2014-2018 онуудад үүссэн 661.7 сая төгрөгийн авлагатай, үүнээс 459.9 сая төгрөгийг шийдүүлэхээр шүүхийн байгууллагад хандсан. /Зорчигч тээврийн нэгтгэл/
- Нийслэлийн 23 дугаар сургуулийн гадна талбайд хийгдэх мөсөн гулгуурын талбай бүхий спорт цогцолборын урьдчилгаа санхүүжилтэд ЧД-ийн хөрөнгө оруулалтаас 270.0 сая төгрөгийг олгосон боловч гэрээний үүргийг хангаагүйгээс авлага үүссэн.
- Төрийн санд бүртгэлтэй 305.7 сая төгрөгийн авлага нь 1994-1996 онд үүссэн найдваргүй авлага, Сангийн Яамнаас махны нөөц бүрдүүлэх зорилгоор авсан зээл, Ард, Даатгал банкнуудыг татан буугдахад үүссэн авлага зэргээс бүрджээ.

Авлага төлөгдөхгүй удах нь цаашид төлөгдөх магадлал буурахаас гадна эзэн холбогдогч тодорхойгүй болох, чанаргүй авлага нэмэгдэх эрсдэлтэй.

Капитал банк дампуурсантай холбоотой Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын 1,974.0 сая, ЖДҮҮДТ ОНӨТҮГ 3,711.6 сая, ОСНААУГ ОНӨААТҮГ-ын 492.7 сая төгрөгийн авлага тус тус үүссэн.

*Аудитын илрүүлэлт:*

*Авлагын данстай холбоотой нийт 12,712.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:*

- *2014-2016 онд хадгаламж зээлийн хоршоодод олгосон үндсэн зээл болон хүүгийн авлага гэрээний дагуу барагдаагүйгээс үндсэн зээл 7,927.7 сая, хүүгийн авлага 61.8 сая, нийт 7,989.5 сая төгрөгийн авлага тайлагнасан. /Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар 7,989.5 сая төгрөг/*
- *Тооцоо нийлсэн актаар 1,680.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй. /Тухайлбал, Багахангайн мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ 1,088.1 сая, ОСНААУГ ОНӨААТҮГ 139.8 сая, Чандмань Налайх ОНӨААТҮГ 102.1 сая, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК 80.2 сая төгрөг/*
- *Авлага бууруулаагүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй. /Нийтийн тээврийн үйлчилгээний газар 1,536.7 сая төгрөг/*
- *Шүүхийн шийдвэртэй 11.3 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаас 1,135.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. /Нийтийн тээврийн үйлчилгээний газар 1,147.1 сая төгрөг/*
- *Олон жил болсон эзэн холбогдогч нь тодорхойгүй 23.2 сая төгрөгийн авлага, өглөг барагдуулаагүй. /Баянгол сэлбэ ОНӨТҮГ/*

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 11,721.6 сая, эцсийн үлдэгдэл 25,099.9 сая төгрөг болж, 13,378.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | 4,408.0 | 12,848.1 | 8,440.1 |
| Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 2,798.3 | 2,983.9 | 185.6 |
| Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 4,263.3 | 9,245.4 | 4,982.1 |
| Цалингийн урьдчилгаа | 11.3 | 7.4 | (3.9) |
| Томилолтын урьдчилгаа | 240.7 | 15.1 | (225.6) |
| **Дүн** | **11,721.6** | **25,099.9** | **13,378.3** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 4,101.2 | 12,101.0 | 7,999.8 |
| Төсөл/ сан | - | | |
| Төрийн сан | - | | |
| ОНӨҮГ | 7,620.4 | 12,998.9 | 5,378.5 |
| **Дүн** | **11,721.6** | **25,099.9** | **13,378.3** |

*Эх сурвалж: Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдлийн өмнөх оноос 2.1 дахин өсөхөд Нийтийн тээврийн үйлчилгээний газар нь нийтийн тээврийн шинэ төсөл, парк шинэчлэлт, хүүхдийн сургуулийн автобус төслийн хүрээнд худалдан авах 75 автобусны урьдчилгаа 6,915.0 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлын тооцоо дансанд бүртгэсэн, Улаанбаатар спорт менежмент ХК спорт цогцолборын дэд бүтцийн гэрээт ажлуудын гүйцэтгэлийн санхүүжилтийн урьдчилгаанд 4,884.1 сая төгрөг олгосон, Хан-Уул дүүргийн Орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас 1,427.1 сая төгрөгийн урьдчилгааг гүйцэтгэгчид олгосон зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдлийн 64.4 хувь нь Улаанбаатар спорт менежмент ХК болон Нийтийн тээврийн үйлчилгээний газарт бүртгэлтэй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилгаа дансанд 25,099.9 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнаснаас он удаан жил болсон дараах урьдчилгаа өнөөг хүртэл хаагдаагүй байна. Үүнд:

- Патентын төлбөр 1,879.0 сая, ажилчдын орон сууцны 362.0 сая, хашаа хийлгэсэн ажлын хөлс 70.0 сая, нийт 2,311.8 сая төгрөгийн 2015-2018 онуудад үүссэн урьдчилгаа /Зорчигч тээврийн нэгтгэл/
- Зураг төслийн ажил гүйцэтгүүлэхээр ААН-д төлсөн 344.7 сая төгрөгийн 2017 онд үүссэн урьдчилгаа /Олон улсын худалдаа, логистикийн төв ХК/
- Эмээлт Баруун туруунд шалган бүртгэх товчоонд автомат хаалт болон хяналтын систем суурилуулалтын ажлын хөлс 55.7 сая төгрөгийн 2012 онд үүссэн урьдчилгаа /Нийслэлийн Мэдээлэл технологийн газар/

*Аудитын илрүүлэлт:*

*Урьдчилгаа дanстай холбоотой нийт 618.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:*

- *Урьдчилж төлсөн зардлын 122.0 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. /ЧД-ийн Засаг даргын Тамгын газар/*
- *Ажил гүйцэтгэж эхлээгүй байхад гэрээ байгуулсан даруйдаа урьдчилгаа төлбөрийн 50-80 хувийг шууд олгосон. /НЗДТГ 412.9 сая төгрөг/*
- *Түр хамгаалах байрны засварын зардлын 57.0 сая, грашийн төлбөрийн 1.8 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардалд бүртгээгүй. /БГД/*

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 78,676.7 сая, эцсийн үлдэгдэл 90,511.3 сая төгрөг болж, 11,834.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалттай материал | 4,882.8 | 4,688.3 | (194.5) |
| Эм боох материал | 171.0 | 463.3 | 292.3 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 8,943.1 | 8,339.7 | (603.4) |
| Бэлэн бүтээгдэхүүн | 678.9 | 507.0 | (171.9) |
| Бичиг хэргийн материал | 1,756.6 | 1,822.4 | 65.8 |
| Аж ахуйн материал | 19,852.4 | 23,782.0 | 3,929.6 |
| Сэлбэг хэрэгсэл | 2,502.7 | 2,562.7 | 60.0 |
| Түлш, шатах тослох материал | 463.2 | 517.0 | 53.8 |
| Барилгын засварын материал | 584.5 | 789.1 | 204.6 |
| Хүнсний материал | 2,249.1 | 419.6 | (1,829.5) |
| Бусад хангамжийн материал | 36,511.4 | 46,548.7 | 10,037.3 |
| Биологийн хөрөнгө | 1.4 | 2.1 | 0.7 |
| Мал амьтад | 79.6 | 69.4 | (10.2) |
| **Дүн** | **78,676.7** | **90,511.3** | **11,834.6** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 52,872.9 | 59,604.8 | 6,731.9 |
| Төсөл/ сан | | 187.4 | 187.4 |
| Төрийн сан | | - | - |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 25,803.8 | 30,719.2 | 4,915.4 |
| **Дүн** | **78,676.7** | **90,511.3** | **11,834.6** |

*Эх сурвалж: Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд бараа материал худалдан авсан 135,438.7 сая, балансаас балансsucc болон ангилал хооронд шилжүүлсэн 4,140.6 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 7,619.0 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 105,548.9 сая, балансаас балансг болон ангилал хооронд шилжүүлсэн, акталсан 29,815.1 сая төгрөгөөр хасагдсан.

Дуусаагүй үйлдвэрлэл дансанд 8,339.7 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан бөгөөд үүнд Улаанбаатар зам засвар арчлалт ОНӨААТҮГ он дамжиж хийгдсэн 5,448.0 сая, хөрөнгө оруулалтаар хийгдсэн боловч холбогдох байгууллагын шийдвэр гараагүйгээс хөрөнгөд бүртгээгүй 2,891.7 сая төгрөгийн ажил /БЗД-ийн ОНХС 94.8 сая, хөрөнгө оруулалт 82.0 сая, НД-ийн Цэцэрлэгжүүлэлтийн алба 662.3 сая, БГД-ийн хөрөнгө оруулалт 1,999.5 сая, Бэлчээрийн менежмент төслийн нэгж 40.1 сая, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк 13.0 сая төгрөг/ бүртгэсэн байна.

<u>Нөөцийн бараа</u>

Нөөцийн бараа материалын эхний үлдэгдэл 267.1 сая, эцсийн үлдэгдэл 41.0 сая төгрөг болж, 226.1 сая төгрөгөөр буурсан. Нөөцийн бараа дансанд Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ-ын 41.0 сая төгрөгийн давсны нөөц бүртгэлтэй байна.

<u>Бусад эргэлтийн хөрөнгө</u>

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 389,705.4 сая, эцсийн үлдэгдэл 929,981.3 сая төгрөг болж, 540,275.9 сая төгрөгөөр өссөн. Бусад эргэлтийн хөрөнгө дансанд нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 800,582.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. /НХОГ ОНӨААТҮГ 531,533.8 сая, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар 260,457.3 сая, ЧД 6,526.4 сая, ХУД 1,924.8 сая, БГД 140.2 сая төгрөг/. Мөн Нийслэлийн Орон сууцны корпораци ХК 115,281.4 сая төгрөгийн борлуулах

зорилгоор эзэмшиж буй түрээслээд өмчлөх нөхцөлтэй 1382 иргэний орон сууц, газраа орон сууцаар сольсон иргэдийн 14,117.4 сая төгрөгийн газар, нийт 129,398.8 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Бараа материалын данстай холбоотой 1,613.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:*

- *Бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 275.9 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Тухайлбал, ЧД 92.4 сая, СБД 85.3 сая, БЗД 39.2 сая төгрөг/*
- *Анхан шатны баримт бүрдэл дутуу, ашиглалтын хугацаа дуусаагүй ашиглалтад байгаа хөрөнгүүдийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /НЗДТГ 348.3 сая төгрөг/*
- *Ашиглалтын норм нормативыг харгалзалгүйгээр 211.4 сая төгрөгийн хангамжийн материал зарлагадсан. /БЗД/*
- *Бэлгэнд өгөх зориулалтаар зөөврийн компьютер бэлтгэж, бараа материалын дансанд бүртгэсэн. /НЗДТГ 62.5 сая төгрөг/*
- *Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор бусад хангамжийн материалын тооцоог бодоогүй, акт үйлдээгүй. /Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба 102.2 сая төгрөг/*
- *Жилийн эцсийн тооллогыг хийхдээ илтгэх хуудас, тооцоо бодсон акт дутуу хөтөлсөн, бараа материалын тайланг нэр төрөл тус бүрээр сар бүр бэлтгээгүй, шаардах хуудас, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй. /ОСНААУГ ОНӨААТҮГ 65.4 сая төгрөг/*
- *Нийт 129.4 сая төгрөгийн бараа материалын ангилал буруу бүртгэсэн. /Тухайлбал, ЧД 71.9 сая, БЗД 29.3 сая төгрөг/*
- *Бараа материалын дансанд 115.2 сая төгрөгийн принтерийн хор, багаж, хангалтын материал, нормын хувцас зэрэг барааг хэрэгцээнээс илүү татан авч төсвийг үр ашиггүй зарцуулсан. /"Баянгол Шинэ өргөө" ОНӨААТҮГ/*
- *Тээврийн хэрэгсэлгүй болович жилийн эцэст шатахуун их хэмжээгээр нөөцөлсөн. /Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар 8.0 сая төгрөг/, шатах тослох материалын мөнгөн талон их хэмжээгээр нөөцөлсөн. /Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар 3.3 сая төгрөг/*

### 3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,867,686.5 сая, эцсийн үлдэгдэл 2,870,343.6 сая төгрөг болж, 2,657.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Биет хөрөнгө | 1,963,650.5 | 1,999,725.8 | 36,075.3 |
| Биет бус хөрөнгө | 890,979.5 | 824,319.8 | (66,659.7) |
| Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 13,056.5 | 46,298.0 | 33,241.5 |
| **Дүн** | **2,867,686.5** | **2,870,343.6** | **2,657.1** |
| *Үйлчилгээ, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 2,021,694.3 | 1,973,455.0 | (48,239.3) |
| Төсөл/ сан | | 249.8 | 249.8 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 845,992.2 | 896,638.8 | 50,646.6 |
| **Дүн** | **2,867,686.5** | **2,870,343.6** | **2,657.1** |

*Эх сурвалж: Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 33,569.6 сая, балансаас балансаас шилжүүлэн авсан, ангилал зассан 159,793.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 120,696.4 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас балансаас шилжүүлсэн, ангилал зассан 147,159.4 сая, акталсан 22,761.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга данс 13,685.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оноос 10,930.4 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд дараах хөрөнгүүд бүртгэлтэй байна. Үүнд:

Өмнөх онд бүртгэлтэй байсан:

- УСУГ ОНӨААТҮГ-ын ажилтнуудын амьдардаг, Батлан хамгаалах яамны өмчлөлийн байрны дээвэр болон орцны дотор заслын 415.8 сая төгрөгийн ажлыг өмчлөлийн маргаантай шалтгаанаар дуусаагүй барилга дансанд бүртгэсэн;
- НӨАУГ нь Урт цагааны үйлчилгээний төвийн 22 түрээслэгчийн хөрөнгө оруулалт, Улаанбаатар даатгалын хувьцаа нийт 288.7 сая төгрөгийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн;
- БЗД-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд 2011 онд хийгдсэн 325.0 сая төгрөг өртөгтэй хөл бөмбөгийн талбайн зураг төслийн үнэ, 2014 онд баригдсан 541.7 сая төгрөгийн өртөгтэй Хонхорын эмнэлгийн барилга бүртгэсэн байна. Дээрх зураг төслөөр ажил хийгдээгүй, эмнэлгийн барилгыг улсын комисс хүлээж аваагүй шалтгаанаар дуусаагүй барилгад бүртгэжээ;
- БХД-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дуусаагүй барилга дансанд хуучин орос цэргийн хотхоны байрыг 743.6 сая төгрөгөөр бүртгэсэн;
- БГД-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Хүүхдийн зуслангийн 105.9 сая төгрөгийн цахилгааны дэд станц бүртгэсэн.

Тайлант онд нэмэгдсэн:

- Улаанбаатар спорт менежмент ХК 10,062.3 сая төгрөгийн спорт цогцолборын барилга;
- УСУГ ОНӨААТҮГ 1,175.8 сая төгрөгийн ахмадын сувиллын барилга;

Мөн дуусаагүй барилга дансанд Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ барилгын засварын 18.8 сая, Чандмань Налайх ОНӨААТҮГ барилга буулгахтай холбогдон гарсан 8.2 сая төгрөгийн зардал бүртгэсэн байгааг холбогдох шийдвэр гаргаж залруулах нь зүйтэй.

*Аудитын илрүүлэлт:*

*Үндсэн хөрөнгийн данстай холбоотой 6,998.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:*

- *Жилийн эцсийн тооллогоор 3,926.1 сая төгрөгийн хөрөнгийг тоолоогүй мөн Ахмадын амралт сувилал ОНӨААТҮГ нь 2018 оны 1 дүгээр сарын 01-нд барилга, байгууламж нь галд өртсөний улмаас өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулаагүй болович дүүргийн нэгдсэн тайланд тус байгууллагын 605.5 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бараа материал тайлагнасан. Барилга байгууламж, хөрөнгийн асуудлыг эрх бүхий байгууллагуудад тавьж шийдвэрлэх арга хэмжээ аваагүй 3 жил болсон. /ЧД 4,531.6 сая төгрөг/*
- *Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2013 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 300/01 тогтоолоор битүүмжилсэн үйлдвэрийн байранд байгаа 296.8 сая төгрөгийн бараа материал, 789.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг баталгаажуулаагүй. /Багахангайн мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ 1,086.7 сая төгрөг/*
- *Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 296.3 сая төгрөгийн биет бус /20 дугаар хорооны ерөнхий төлөвлөгөө/ хөрөнгийг шууд зардлаар тайлагнасан. /БЗД/*
- *Биетээр хүлээн аваагүй тээврийн хэрэгслийг балансад бүртгэж элэгдэл байгуулсан. Нийслэлийн /Улаанбаатар чуулга 89.8 сая төгрөг/*
- *"Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, 227.1 сая төгрөгийн дансны үнэтэй, 1956 онд ашиглалтад орсон, ашиглалтын шаардлага хангахгүй болсон талаар Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт бүхий конторын барилгыг хураалгахдаа эрх бүхий байгууллагын зөвшөөрөл аваагүй байна. /НД/*
- *НЗД-ын захирамж зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл худалдан авсан. /НХОГ ОНӨААТҮГ 96.7 сая төгрөг/*
- *Тоног төхөөрөмжийн данс бүртгэлтэй 40 ширхэг IPAD биетээр байхгүй. /СБД 62.0 сая төгрөг/*

### 3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 419,593.6 сая, эцсийн үлдэгдэл 992,131.8 сая төгрөг болж, 572,538.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| *Богино хугацаат өр төлбөрийн дүн* | 83,317.0 | 144,444.0 | 61,127.0 |
| Өглөг | 53,234.7 | 92,985.4 | 39,750.7 |
| Урьдчилж орсон орлого | 30,082.3 | 51,458.6 | 21,376.3 |
| *Урт хугацаат өр төлбөрийн дүн* | 336,276.6 | 847,687.8 | 511,411.2 |
| Урт хугацаат зээл | 336,276.6 | 847,687.8 | 511,411.2 |
| **Дүн** | **419,593.6** | **992,131.8** | **572,538.2** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | - | |
| Төсөвт байгууллага | 41,211.7 | 283,990.3 | 242,778.6 |
| Төсөл/ сан | - | - | - |
| Төрийн сан | - | - | - |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 378,381.9 | 708,141.5 | 329,759.6 |
| **Дүн** | **419,593.6** | **992,131.8** | **572,538.2** |

*Эх сурвалж: Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 49,594.5 сая төгрөгийн барьцаа, 43,390.9 сая төгрөгийн дансны өглөг, 51,458.6 сая урьдчилж орсон орлого тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар богино хугацаат өр төлбөрийн дансанд БЗД 5,776.5 сая, Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ 4,978.3 сая, НД 4,862.4 сая, Багахангайн мах боловсруулах үйлдвэр 468.6 сая, нийт 14,085.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөр тайлагнасан байна. Мөн Нийслэлийн төрийн санд 2011-2014 онд үүссэн нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 16 ажлын 1,010.8 сая төгрөгийн барьцаа байршиж байгаа бөгөөд дээрх үлдэгдлийг холбогдох байгууллагын шийдвэрээр зохих байгууллагад нь шилжүүлэх, орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх зэргээр барагдуулах нь зүйтэй.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 21,376.3 сая төгрөгөөр нэмэгдэхэд Нийслэлийн Орон сууцны корпораци ХК урьдчилж орсон орлого дансанд 9,353.2 сая төгрөгийн түрээсийн орон сууцыг капиталын аргаар бүртгэсэн, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ цахилгаан автобусны урьдчилгаа 5,300.0 сая төгрөгийг бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Урт хугацаат өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 847,687.8 сая төгрөг болж, 511,411.2 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үүнд Нийслэлийн Орон сууцны корпораци ХК 258,003.9 сая төгрөг (*иргэдийн барьцаа төлбөр 2,565.3 сая, 802 иргэний байрны өглөг 71,165.4 сая, БУ-2 байрны өглөг 40,055.0 сая, НТАХ-ын байрны өглөг 5,497.7 сая, "НОСК хоёр тусгай зориулалттай" ХХК-ийн байрны өглөг 35,192.9 сая, Монгол банкны 34,355.5 сая, Хөгжлийн банкны 69,172.1 сая төгрөгийн зээл*), Нийслэлийн Төрийн сан Сангийн Яамтай тооцоо нийлж гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалт, нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалт зэрэг нийт 243,102.5 сая төгрөгийн 10 дамжуулан зээлийг бүртгэсэн.

УСУГ, ОСНААУГ, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ууд нь нийт 260,804.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй бөгөөд зээлийн үлдэгдэл нь гадаад валютын ханшийн тэгшитгэл хийсэн 19,681.1 сая төгрөгөөр нэмэгджээ.

*Аудитын илрүүлэлт:*

*Өр төлбөрийн данстай холбоотой 1,482.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:*

- *Нийт 1,065.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажаагүй. Тухайлбал, НХОГ ОНӨААТҮГ 659.1 сая, УСУГ ОНӨААТҮГ 129.5 сая, БЗД*

*121.4 сая, ХУД 60.9 сая, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба 45.5 сая, СХД 32.4 сая, төгрөг*

- *Хөрөнгө оруулалтын ажлуудын гэрээнд тусгагдсан 262,7 сая төгрөгийн барьцаа чөлөөлөх хугацаа дууссан, гүйцэтгэгч байгууллагад ажил дүгнэж олгоогүй, төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлээгүй. /НХОГ ОНӨААТҮГ 53.9 сая, УСУГ ОНӨААТҮГ 37.2 сая, Нийслэлийн Мэдээлэл технологийн газар 19.3 сая төгрөг, БЗД 99.4 сая, БГД 40.9 сая, ХУД 9.9 сая, БХД 2.1 сая төгрөг/*
- *Байгууллагад төлөх өмнөх оны өглөгийг бүртгээгүй. /ОСНААУГ ОНӨААТҮГ 38.0 сая төгрөг/*
- *Санхүүгийн тайланд өр төлбөр дутуу тайлагнасан. /Нийтийн тээврийн үйлчилгээний газар 33.1 сая төгрөг/*

### 3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,347,389.8 сая, эцсийн үлдэгдэл 3,459,065.2 сая төгрөг болж, 111,675.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 1,083,222.0 | 1,010,600.1 | (72,621.9) |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 289,318.2 | 351,212.8 | 61,894.6 |
| Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/ | 44,472.2 | | (44,472.2) |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 372,114.9 | 396,080.6 | 23,965.7 |
| Хуримтлагдсан үр дүн | 741,246.8 | 892,384.8 | 151,138.0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 817,015.7 | 808,786.9 | (8,228.8) |
| **Дүн** | **3,347,389.8** | **3,459,065.2** | **111,675.4** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 2,135,049.5 | 2,110,085.7 | (24,963.8) |
| Төсөл/ сан | 31,697.6 | 32,140.3 | 442.7 |
| Төрийн сан | 171,884.5 | 160,965.2 | (10,919.3) |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 1,008,758.2 | 1,155,874.0 | 147,115.8 |
| **Дүн** | **3,347,389.8** | **3,459,065.2** | **111,675.4** |

*Эх сурвалж: Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын сан дансны эцсийн үлдэгдэл 1,010,600.1 сая төгрөг болж, 72,621.9 сая төгрөгөөр буурсан нь Монгол наадам цогцолбор ОНӨААТҮГ-ын Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 109 дүгээр тогтоолоор эзэмшиж буй газрыг улсын тусгай хэрэгцээнд Барилга хот байгуулалтын яам руу шилжүүлснээс шалтгаалжээ.

Төрийн өмчийн дансны үлдэгдэл 351,212.8 сая төгрөг болж, 61,894.6 сая төгрөгөөр өссөн нь Нийслэлийн Орон сууцны корпораци ХК 44,472.2 сая төгрөгийн төрийн өмчид хувьцаат өмч дансыг залруулж бүртгэсэн, Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ХК-ний дүрмийн санг 4,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, ОСНААУГ ОНӨААТҮГ нь Нийслэлийн Засаг даргын 2020 оны 6 дугаар сарын 16-ны А/828 дугаар захирамж, НӨАУГ-ын даргын 2020 оны 5 дугаар сарын 3/1040 дүгээр албан бичгийн дагуу улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4,340.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлж бүртгэснээс тус тус шалтгаалсан байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 396,080.6 сая төгрөг болж 23,965.7 сая төгрөгөөр өсөхөд УСУГ ОНӨААТҮГ 13,495.5 сая, Нийслэлийн орон сууцны корпораци ХК 7,700.4 сая, ХИХУГ ОНӨААТҮГ 1,962.2 сая төгрөгөөр тус тус хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авснаас голлон шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл тайлант онд 892,384.8 сая төгрөг болж, 151,138.0 сая төгрөгөөр өссөн.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 808,786.9 сая төгрөг болж, 8,228.8 сая төгрөгөөр буурсан нь СХД-ийн Ирээдүй цогцолбор нь 3 цогцолбор сургууль

болж салсан, ХУД-ийн 10 дугаар сургууль, 121 дүгээр цэцэрлэгийн барилгыг холбогдох байгууллагын шийдвэрээр данснаас хассан нь шалтгаалжээ.

Тайлант онд нийслэлийн санхүүгийн нэгтгэсэн тайланд НББ-ийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга дансанд 164,758.9 сая төгрөг бүртгэгдсэнээс НХОГ ОНӨААТҮГ 152,477.9 сая төгрөгийн залруулга хийсэн нь өмнөх оны хэрэгжээгүй ажлын техник хяналтын 2.3 сая төгрөгийн авлагын дүнгээр өмнөх үеийн үр дүнг бууруулж, 178,380.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг шинээр бүртгэж, 25,900.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох тогтоол шийдвэрийн дагуу ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Үнэт цаас гаргах тогтоол, шийдвэрт үнэт цаасны тоо, төрөл, гаргах хугацаа, нөхцөлийг заагаагүй. /Нийслэлийн Орон сууцны корпораци ХК/*
- *Санхүүгийн тайланд тусгагдсан эздийн өмчийн дүн улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс зөрүүтэй. /Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК, Хүнс хангамж төв ОНӨААТҮГ, ХИХУГ ОНӨААТҮГ, Чандмань Налайх ОНӨААТҮГ, СХД-ийн Тээвэрлэлт үйлчилгээний төв ОНӨААТҮГ /*
- *Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 17150 дугаартай, Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороонд байрлах, 608 мкв газар эзэмших эрхийг "Нийтийн ахуйн үйлчилгээний төв"-ийн зориулалттайгаар газрыг гэрчилгээг гаргуулан авсныг санхүүгийн тайланд тусгаагүй. /Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК/*

### 3.5.8 Орлогын данс

Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 2,157,765.3 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого, 726.7 сая төгрөгийн үйл ажиллагааны бус орлого, нийт 2,158,492.0 сая төгрөгийн орлого тайлагнасан.

*Аудитын илрүүлэлт:*

*Орлогын данстай холбоотой 297.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:*

- *Орлогын төлөвлөгөө биелүүлээгүй. /Замын хөдөлгөөний удирдлагын төв/*
- *Хог хаягдлын хураамжийн орлогыг татварын албанд дутуу төвлөрүүлсэн. /БЗД 201.1 сая төгрөг/*
- *Түрээсийн гэрээ байгуулалгүй орлого төвлөрүүлсэн. /НӨАУГ 66.3 сая төгрөг/*
- *Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК нь 5 жилийн хугацаанд 2,400.0 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангалтгүй, 2020 онд татаас, санхүүжилтийн орлогоос гадна 450.0 сая төгрөгийн үйл ажиллагааны орлоготой ажиллахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 13.5 сая төгрөгийн орлоготой ажилласан, компанийн эрхэм зорилгын хэрэгжилт хангагдаагүй байна.*

### 3.5.9 Зардлын данс

Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 1,773,710.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 398,079.0 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал, нийт 2,171,789.5 сая төгрөгийн зардал тайлагнасан.

*Аудитын илрүүлэлт:*

*Зардлын данстай холбоотой 9,202.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн, зориулалт бус болон үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан 1,582.7 сая төгрөгийн зөрчлийг Нийслэлийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд оруулсан. Зардлын данстай холбоотой зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:*

- ***Цалингийн зардал:** Цалин, нэмэгдэл, урамшуулал, ээлжийн амралтын олговор зөрүүтэй тооцож олгосон, дансны бичилт буруу бүртгэсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар цалин, нэмэгдэл олгосон, холбогдох татвар, шимтгэлийн суутгалыг зөрүүтэй суутгасан, үр дүнгийн урамшуулал хавтгайруулан олгосон, төсөв хэтрүүлсэн зэрэг цалингийн зардалтай холбоотой 2,124.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Тухайлбал, ЧД 905.6 сая, БЗД 516.3 сая, ХУД 138.9 сая, БНД 45.8 сая, БГД 34.4 сая, СХД 17.5 сая, Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар 124.1 сая, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар 55.2 сая, УСУГ ОНӨААТҮГ 40.0 сая, Нийслэлийн хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ 55.3 сая, Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ 32.0 сая төгрөг/*
- ***Дүүргийн хөрөнгө оруулалт:** Хөрөнгө оруулалтаар хийсэн 679.9 сая төгрөгийн хөрөнгийг орлогод бүртгээгүй, зарцуулагдаагүй үлдэгдэл 36.6 сая төгрөгийг барьцаа дансанд шилжүүлж, орон нутгийн төсвийн орлогын ерөнхий дансанд төвлөрүүлээгүй, хөрөнгө оруулалтаар нэмж төсөв батлан тендер зарлаж, төсвийн хөрөнгийг 375.4 сая төгрөгөөр үрэлгэн зарцуулсан, урсгал санхүүжилтийн шинж чанартай, дүүргийн нутаг дэвсгэрт ариутгал халдваргүйжүүлэлтийн ажилд зориулан 394.2 сая төгрөгийг батлуулж, зарцуулсан /БЗД 1,486.1 сая төгрөг/, он дамжин хийгдсэн 45.7 сая төгрөгийн тохижилтын ажил үр ашиггүй болж, тухайн хөрөнгийг бүртгэлд авсан ч биетээр байхгүй, Баянгол дүүргийн Замын Цагдаагийн хэлтсийн 48.3 сая төгрөгийн барилгын гадна тохижилтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй. /БГД 94.0 сая төгрөг/, хөрөнгө оруулалтын санхүүжилт 139.7 сая төгрөгийг барьцаа дансанд шилжүүлж, төсвийн орлогын ерөнхий дансанд төвлөрүүлээгүй. /БНД 139.7 сая төгрөг/, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллаагүй, хороодын иргэний танхимд тоног төхөөрөмж, техник хэрэгсэл бэлтгэсэн. /СХД 69.8 сая төгрөг/, орон нутгийн хөрөнгө оруулалтаар худалдаж авсан тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн үнийн дүнгээс барьцаа суутгаагүй. /ЧД 17.6 сая төгрөг/*
- ***Худалдан авалт:** Нэг ижил төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа харьцуулалтын арга хэрэглээгүй, шууд гэрээ байгуулсан. /БЗД 1,159.0 сая, НЗДТГ, Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ 429.6 сая, ОСНААУГ ОНӨААТҮГ 143.0 сая, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ 106.4 сая, Нийслэлийн Улаанбаатар чуулга 22.0 сая, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн 20.0 сая төгрөг/;*

  *Худалдан авах ажиллагаанд шингэн битум нийлүүлэх тендер эхний шатны шалгуур хангасан байгууллага байхгүй ба 2 дахь удаагийн тендер шалгаруулалтаар 1 байгууллага санал ирүүлсэн хэдий ч тендерийн ерөнхий шаардлагаас зарим шаардлага хангаагүй байхад гэрээ хийсэн. /Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ 2,613.7 сая төгрөг/;*

  *Харилцах дансны зарлагын гүйлгээг анхан шатны дутуу баримтаар зарцуулсан. (худалдан авалтын гэрээгүй, тооцоо нийлсэн акт бүрэн хөтлөөгүй, ажил дууссан мэдэгдэх хуудасгүй, хүлээн авсан актгүй, үйл ажиллагааны чиглэл өөр) /ОСНААУГ ОНӨААТҮГ 601.8 сая төгрөг/;*

  *Шатахуун худалдан авахдаа худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй. /СБД 387.3 сая төгрөг/;*

  *Нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулах торхтой модны сав нийлүүлэх ажлын тендерийн бичиг баримтыг боловсруулахдаа тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлага, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадварыг шалгуурт оруулж өгөөгүй. /Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба 507.5 сая төгрөг/;*

  *Гэрээгээр нийлүүлсэн хог тээврийн 3 автомашин нь техникийн тодорхойлолтод заасан хэмжээнээс (авто машины даацыг 4700 кг гэж заасан) гаалиар орж ирсэн мэдүүлэгт авто машины даацыг тус бүр 2000 кг гэж тусгасан боловч техникийн тодорхойлолтод тавигдсан шаардлагыг хангахгүй тээврийн хэрэгсэл нийлүүлсэн. /Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба 188.0 сая төгрөг/;*

  *Хог тээврийн тусгай зориулалт бүхий тээврийн хэрэгслүүдэд дизелийн түлш нийлүүлэх" тендер сонгон шалгаруулалтад "Ти Энд Ти Петролеум" компани 602.0 сая төгрөгийн үнийн саналаар шалгарсан байна. Уг үйл ажиллагааны явцад "Гэрээ байгуулах эрх олгох тухай" Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ-ын даргын "Ти Энд Ти Петролеум" компанид явуулсан албан бичиг он сар өдөр, албан бичгийн дугааргүй, тендер шалгаруулалт, түлш нийлүүлэх гэрээ хийгдсэний дараа дизелийн түлш нийлүүлэх үнийг 796.0 сая төгрөг болгон нэмсэн. /Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ 796.0 сая төгрөг/*
- ***Шатахууны зардал:** Шатахууны зарцуулалтыг тогтоосон жишиг нормоос 139.0 сая төгрөгөөр илүү зарцуулсан. /БЗД /,*

  *Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого, зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгосон талоноор зардалд бүртгэсэн,*

*захирамж, тушаалаар авч зарцуулсан талон, шатахуун тослох материалын худалдан авалтыг материалын тайланд орлого, зарлага авч тайлагнаж, баталгаажуулаагүй. /БЗД 53.7 сая төгрөг/,*

*Шатахууныг нэг бүрийн үнээр бүртгээгүй бэлтгэн нийлүүлэгчид шилжүүлсэн дүнгээр, талоны дэвсгэртээр орлого, зарлагыг бүртгэсэн, хэмжих нэгжийг буруу бүртгэсэн, шатах тослох материалын тайланг буруу гаргасан. /ЧД 37.8 сая төгрөг/*

- ***Бусад:** Дэмжлэг олгоход баримталсан үндэслэл, шалтгаан, шалгуур үзүүлэлт, ажлын үр дүн тодорхой бус, тусдаа төсөвтэй байгууллага, дүүргийн албан хаагчдад хавтгайруулан олгосон, уг орлогоос ХХОАТ суутгаагүй, Нийслэлийн төр захиргааны байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тэдэнд зориулан орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд 75 байрны хуваарилалтыг хийж гүйцэтгэхдээ нийслэл болон орон нутгийн биш байгууллагуудад орон сууцыг хуваарилж тухайн байгууллагуудын албан хаагчид хамрагдсан, тухайлан нэг хэлтэс тасаг зааж оноож хуваарилсан, нийслэлийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд 10.0 тэрбум төгрөгийн төсөв баталж зарцуулахдаа баримтлах дүрэм, журам, шалгуур үзүүлэлт тодорхой бус, төслийн зорилго хоорондоо хамааралгүй, уялдаагүй, тайлант онд бүрэн гүйцэт хэрэгжээгүй, үлдэгдэл санхүүжилтийн ажлын явц тодорхойгүй. /НЗДТГ/,*

  *Бүрдэл дутуу анхан шатны баримтаар 215.7 сая төгрөгийн гүйлгээ хийсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйл ажиллагаатай холбоотой төсвийг дүүргийн ИТХ-ын тогтоолоор батлуулалгүйгээр ТББ руу 193.0 сая төгрөг шилжүүлсэн, захирамж, тушаал шийдвэргүй, хэвлэл мэдээллийн 35 байгууллагатай 180.0 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх шууд гэрээ байгуулан төлбөрийг бүрэн шилжүүлсэн, тухайн байгууллагуудаас хийсэн ажлын тайлан тодорхой бус, хороодын засвар үйлчилгээнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлаас 16 байгууллагатай нийт 152.3 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх шууд гэрээ байгуулан төлбөрийг бүрэн шилжүүлсэн, тухайн байгууллагуудаас хийсэн ажлын тайлан тодорхой бус. /БЗД 741.0 сая төгрөг/*

## 3.6 ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУД

Нийслэлийн өмчит 23 ААН нийт 275,548.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, өмнөх оноос 449.1 сая төгрөг буюу 0.2 хувиар буурсан.

Үндсэн үйл ажиллагааны зардалд 314,266.6 сая, үндсэн бус үйл ажиллагааны зардалд /гадаад валютын ханшийн зөрүүний гарз 10,184.3 сая, үндсэн хөрөнгийн гарз 462.3 сая төгрөг/ 10,646.6 сая, нийт 324,913.3 сая төгрөгийг зарцуулж, 49,364.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Алдагдал өмнөх оноос 13,067.7 сая төгрөг буюу 36.0 хувиар нэмэгджээ.

Нийслэлийн төсвөөс санхүүжилт авдаггүй, өөрийн үйл ажиллагаагаар орлого бүрдүүлж ажилладаг 23 ААН-ээс 21.7 хувь нь нийт 6,189.7 сая төгрөгийн ашигтай, 78.3 хувь нь 55,554.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. /Хавсралт 1/

Нийслэлийн Засаг даргын 2020 оны захирамжаар нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот 15 байгууллагын 2020 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг баталжээ. Уг захирамжаар дээрх 15 ААН нийт 294,441.4 сая төгрөгийн орлоготой, 346,983.1 сая төгрөгийн зардалтай, нийт 52,541.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар НӨАУГ-тай контрактын гэрээ байгуулжээ.

Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ, Багахангайн мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ, Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци, Олон улсын худалдаа, логистикийн төв, Улаанбаатар спорт менежмент, Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент, Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-уудтай зорилтот түвшний гэрээ байгуулаагүй байна.

Дээрх гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд нийт 267,891.2 сая төгрөгийн орлого, 320,018.6 сая төгрөгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалтай ажиллаж, орлогын төлөвлөгөө нийт 26,550.2 сая төгрөг буюу 9.0 хувиар тасарч, зардлын төлөвлөгөөг 26,964.4 сая төгрөг буюу 7.8 хувиар дутуу зарцуулжээ.

Борлуулалтын орлогын төлөвлөгөөг 2 ААН нийт 6,701.4 сая төгрөг буюу 18.6 хувиар давуулж, 13 ААН нийт 33,251.6 сая төгрөг буюу 12.9 хувиар дутуу бүрдүүлжээ. /Хавсралт 2/

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг 12 ААН нийт 34,688.9 сая төгрөг буюу 11.3 хувиар дутуу, 3 ААН нийт 7,724.5 сая төгрөг буюу 19.6 хувиар илүү зарцуулсан. Зардал илүү зарцуулж байгаа нь НӨАУГ нь зорилтот түвшнийг батлахдаа гадаад валютын ханшийн зөрүүний гарзыг тооцоогүйтэй холбоотой. /Хавсралт 3/

Орлогын төлөвлөгөө тасарсан нь Ковид-19 цар тахлын улмаас үйлчилгээ авдаг ААН-үүд ажиллаагүй, гадаад валютын ханш өссөн зэрэгтэй холбоотой.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд Нийслэлийн ТЕЗ тайлант хугацаанд мэдээлбэл зохих 102 мэдээллээс 61 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийн хугацаа болоогүй, 38 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 869.9 сая төгрөгийн 87 төлбөрийн акт, 17,062.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 74 албан шаардлага, 10,495.2 сая төгрөгийн 567 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт №8. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 87 | 869.9 | 81 | 751.2 | 6 | 118.7 | 93.1 |
| Албан шаардлага | 74 | 17,062.7 | 58 | 6,194.9 | 16 | 10,867.8 | 78.4 |
| Зөвлөмж | 567 | 10,495.2 | 520 | 8,069.3 | 47 | 2,425.9 | 91.7 |
| **Нийт** | **728** | **28,427.8** | **659** | **15,015.4** | **69** | **13,412.4** | **90.5** |

Өмнөх оны аудитаар Нийслэлийн ТЕЗ-д өгсөн зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй боловч Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газраас Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд хадгаламж, зээлийн хоршоогоор дамжуулан иргэдэд олгосон 8.3 тэрбум төгрөгийн барагдуулахаар, Олон улсын худалдаа, логистикийн төв ХК-ийн эзэмшлийн газарт ААН барилга барьсан зөрчлийг арилгах талаар ажиллаж байгаа, Нийтийн тээврийн парк шинэчлэлтэй холбоотой тооцоог барагдуулахаар шүүхэд хандсан тухай албан бичиг ирүүлсэн.

Нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт өгсөн и-баримтын анхан шатны бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн зөрчлийн 21.2 хувийг эзэлж байна.

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

Нийслэлийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 9 дүүргийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлан, 553 төсвийн байгууллага, 9 орон нутгийн тусгай сан, 62 ОНӨААН, нийт 633 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 115 байгууллагад дүгнэлт гаргаж, 510 байгууллагыг түүвэрт хамруулж, 1 байгууллагад итгэл үзүүлж, 7 байгууллага аудитад хамрагдаагүй.

Аудитын дүгнэлт авсан 115 байгууллагаас 2 байгууллага /БЗД-ийн ИТХ, БЗД-ийн ЗДТГ/, "Сөрөг" дүгнэлт, 23 байгууллага "Хязгаарлалттай" дүгнэлт авсан байна.

*Хүснэгт №9. Хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагын жагсаалт*

| д/д | № | Аудитын код | Байгууллагын нэр |
|---|---|---|---|
| **ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ** | | | |
| 1 | 1 | НТАГ-2021/6/СТА-ТТЗ | Баянзүрх дүүргийн Засаг дарга |
| 2 | 2 | НТАГ-2021/8/СТА-ТТЗ | Налайх дүүргийн Засаг дарга |
| 3 | 3 | НТАГ-2021/9/СТА-ТТЗ | Чингэлтэй дүүргийн Засаг дарга |
| **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ** | | | |
| 4 | 1 | НТАГ-2021/539/СТА-ТШЗ | Нийслэлийн Дотоод аудитын газар |
| 5 | 2 | НТАГ-2021/408/СТА-ТШЗ | Нийтийн тээврийн үйлчилгээний газар |
| 6 | 3 | НТАГ-2021/409/СТА-ТШЗ | Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар |
| 7 | 4 | НТАГ-2021/19/СТА-ОНӨТҮГ | Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв |
| 8 | 5 | НТАГ-2021/410/СТА-ТШЗ | Нийслэлийн Улаанбаатар чуулга |
| 9 | 6 | НТАГ-2021/533/СТА-ТШЗ | БГД-ийн ИТХ |
| 10 | 7 | НТАГ-2021/498/СТА-ТШЗ | ЧД-ийн ЗДТГ |
| **ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД** | | | |
| 11 | 1 | НТАГ-2021/26/СТА-ОНӨААН | Асгат ОНӨААТҮГ |
| 12 | 2 | НТАГ-2021/14/СТА-ОНӨААН | Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ |
| 13 | 3 | НТАГ-2021/29/СТА-ОНӨААН | Нийслэлийн хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ |
| 14 | 4 | НТАГ-2021/11/СТА-ОНӨААН | Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК |
| 15 | 5 | НТАГ-2021/48/СТА-ОНӨААН | Багахангайн мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ |
| 16 | 6 | НТАГ-2021/15/СТА-ОНӨААН | Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ |
| 17 | 7 | НТАГ-2021/32/СТА-ОНӨААН | Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ |
| 18 | 8 | НТАГ-2021/39/СТА-ОНӨААН | Чандмань Налайх ОНӨААТҮГ |
| 19 | 9 | НТАГ-2021/21/СТА-ОНӨААН | БЗД-ийн Нийтлэг үйлчилгээний газар-1 ОНӨААТҮГ |
| 20 | 10 | НТАГ-2021/20/СТА-ОНӨААН | БЗД-ийн Нийтлэг үйлчилгээний газар-2 ОНӨААТҮГ |
| 21 | 11 | НТАГ-2021/22/СТА-ОНӨААН | БЗД-ийн Нийтлэг үйлчилгээний газар-3 ОНӨААТҮГ |
| 22 | 12 | НТАГ-2021/33/СТА-ОНӨААН | БЗД-ийн Нийтлэг үйлчилгээний газар-4 ОНӨААТҮГ |
| 23 | 13 | НТАГ-2021/37/СТА-ОНӨААН | Сүхбаатар Дэвшил ОНӨААТҮГ |

Нийслэлийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 146,424.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 91,357.0 сая төгрөгийн алдааг залруулж, 917.2 сая төгрөгийн зөрчилд 76 төлбөрийн акт тогтоож, 25,189.9 сая төгрөгийн зөрчилд 192 албан шаардлага хүргүүлж, 28,960.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1,037 зөвлөмж өгсөн.

<u>*Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар*</u>

